

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 53 дугаар зүйлийн 53.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02/22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын болон нийслэлийн цахим үйлчилгээний цогц системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлын жагсаалтыг 1 дүгээр, төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцооны систем, тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлыг 2 дугаар, газар зүйн мэдээллийн системд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санг өргөжүүлж, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх ажлын жагсаалтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэ захирамжийн хавсралтуудад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэдээллийн технологийн газар /О.Чинзориг/-т, уг арга хэмжээнд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /Э.Болормаа/-т, гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ч.Однасан/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2018 оны
01 дүгээр сарын 24-ний өдрийн
А/67 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН
БОЛОН НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦ
СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЖ, ХЭРЭГЛЭЭНД
НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2018 онд санхүүжих
1	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэж буй програм хангамжуудыг холбож, нэгдсэн платформыг шинээр бий болгож, үе шаттай хөгжүүлэх	2018	492.0	492.0
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн санг шинээр үүсгэж, цахим үйлчилгээний дэд бүтэцтэй холбох, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэн үе шаттай хөгжүүлэх	2018	312.0	312.0
3	Нийслэлийн үйлчилгээний дотоод хяналт удирдлагын систем бий болгох, цахим үйлчилгээний ухаалаг нэгдсэн системийн дэд бүтцийг үүсгэж, төрийн мэдээллийн системтэй холбож нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх	2018	200.0	200.0
4	Нийслэлийн хэмжээний сургуулийн өмнөх боловсролын хүүхдийн мэдээллийн санг үүсгэж эцэг эхчүүдийг мэдээллээр хангах гар утасны аппликейшн хөгжүүлж, бүртгэлийн системийн нэмэлт хөгжүүлэлт хийж нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх	2018	78.0	78.0
5	Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын материаллаг баазыг бэхжүүлэх	2018	60.0	60.0
6	Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний системийн хөгжүүлэлт III шат	2018	150.0	150.0
7	"Албан хэрэг хөтлөлтийн систем", "Байгууллагын архивын систем"-ийн нэмэлт хөгжүүлэлт, системийн аюулгүй ажиллагааг хангах програм хангамжийн нэмэлт хөгжүүлэлт, Тоон гарын үсгээр баталгаажсан цахим албан хэрэг хөтлөлтийг хэрэглээнд нэвтрүүлэх	2018	160.0	160.0
8	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын талбарын удирдлагыг нэвтрүүлэх	2018	48.0	48.0
	ДҮН		1,500.0	1,500.0

Нийслэлийн Засаг даргын 2018 оны
01 дүгээр сарын 24-ний өдрийн
А/67 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦООНЫ
СИСТЕМ, ТООН ГАРЫН ҮСГИЙГ НЭВТРҮҮЛЭХ
АЖИЛ

				/сая төгрөг/
№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2018 онд санхүүжих
1	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад тоон гарын үсгийг нэвтрүүлэх II шат	2018	140.8	140.8
	ДҮН		140.8	140.8

Нийслэлийн Засаг даргын 2018 оны
01 дүгээр сарын 24-ний өдрийн
А/67 дугаар захирамжийн
3 дугаар хавсралт

ГАЗАР ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД СУУРИЛСАН
НИЙСЛЭЛИЙН ДУНДЫН МЭДЭЭЛЛИЙН САНГ
ӨРГӨЖҮҮЛЖ, НИЙТИЙН ХЭРЭГЛЭЭНД
НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2018 онд санхүүжих
1	Орон зайн мэдээллийн систем суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санг өргөжүүлж дэд сангууд үүсгэх, хяналт удирдлага, дүн шинжилгээ хийж нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх	2018	941.5	941.5
2	Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын орон зайн дундын мэдээллийн сангийн дэд бүтэц, програм болон техник хангамжийн өргөтгөл, сургалт	2018	258.5	258.5
	ДҮН		1,200.0	1,200.0